

АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. Төслийн нэр	2
1.2. Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгж байгууллага	2
1.3. Төслийн байршил, тойм зураг	2
1.4. Төслийн хүчин чадал.....	4
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧТОДОРХОЙЛОЛТ	7
3.1 Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ	7
3.2 Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдлын үнэлгээ	7
3.3 Ургамал нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ	8
3.4 Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээ	8
3.5 Усны нөөц, чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ	8
3.6 Төслөөс нийгэм, эдийн засагт нөлөөлөх байдал, үнэлгээ.....	8
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	9
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	10
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	11
ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	11
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	13
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГАЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	15
АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГНӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	15

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

Сонгинохайрхан дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Мах ангилан ялгах, боловсруулах үйлдвэр” төсөл


1.2. Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгж байгууллага

“Хаан хүнс импекс” ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 901176056, Регистрийн дугаар: 5273528

1.3. Төслийн байршил, тойм зураг

“Хаанхүнс импекс” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Мах ангилан ялгах, боловсруулах үйлдвэр” төслийн 0.63 га талбай нь Сонгинохайрхан дүүргийн 1-р хороо, Толгойтод байрлаж байна. Төслийн талбайн топо зургийг *Зураг №1-д*, байр зүйн зургийг *Зураг №2-д* үзүүлээ.

Зураг №1 Төслийн талбайн топо зураг



Зураг №2 Төслийн талбайн байр зүйн зураг



1.4. Төслийн хүчин чадал

Мах ангилан ялгах, боловсруулах үйлдвэр нь түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах агуулах, мах бэлтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх цехүүд, ажилчдын байр гэсэн үндсэн 3 хэсэг болон ажилчдын үйлчилгээний хэсэг, гараж гэсэн хэсгүүдээс бүрдэж байна.

Үйлдвэр нь нийт 6 хэсгээс бүрдэх 140 ажилтантай. Хоногт 10 тн хиаман бүтээгдэхүүн (бүрэн утлагат, чанамал, хагас утлагат хиам), 500-1000 кг хагас боловсруулсан бүтээгдэхүүн (бөөрөнхий мах, бургер, котлет, тефтель, зраз) үйлдвэрлэдэг



ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хүснэгт №1 Байгаль орчны төлөв байдлын товч тодорхойлолт

№	Үзүүлэлтүүд	Утга
1	Уур амьсгал	Улаанбаатар хот нь Хэнтийн нурууны урд үзүүр болох Баянзүрх, Богдхан, Сонгинохайрхан, Чингэлтэй хайрхан уулсаар хүрээлэгдсэн бөгөөд Туул, Сэлбэ голуудын бэлчир хөндийд, далайн түвшнөөс дээш дунджаар 1350 м өндөрт оршдог. Нийт 4.704.4 м ² нутагтай. Улаанбаатар хотын уурамьсгал нь сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай, өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь -49°C (1954 оны 2 дугаар сард) хүрдэг, үнэмлэхүй их температур нь 39.5°C (2005 онд) хүрдэг. Жилийн дундаж температур нь -3°C, хамгийн хүйтэн I сарын температур -26°C байх бөгөөд -30°C -аас доош хүйтрэх өдрийн тоо жилд 40 орчим байна. Цасан бүрхэвч XI сарын 10-ны үед тогтож III сарын хорьд хүртэл 130 орчим хоног 1.8 см орчим зузаан цастай байна. Ууландаа цасны зузаан их, цасан шуургатай өдөр жилдээ 10 орчим байдаг байна.
2	Геологийн тогтоц	Улаанбаатар хотын геологийн тогтоц нь кембри, девон, карбонь эрин үед үүссэн тунамал, хувирмал чулуулаг, тэдгээрийг нэвтэлж газрын гүнд царцаж тогтсон юра, триасын настай боржин чулуулаг, эдгээр үндсэн чулуулгийг бүрхэж тархсан цэрдийн эринд үүссэн цайвар саарал өнгийн элсжин, зануужин, гуравдагчийн улаан, улаавтар шар өнгийн хайргатай элсэрхэг болон наанги шавар, шавранцар, элсний нимгэн үе, дөрөвдөгчийн үед үүссэн элс, хайрга, шавар, хайргажин зэрэг хурдас, чулуулгаас бүрддэг.
3	Агаарын чанар	Улаанбаатар хот нь хөл хөдөлгөөн ихтэй тул тус авто зам жилийн дөрвөн улиралд байнгын ачаалалтай байдаг бөгөөд автомашины хөдөлгөөнөөс ялгарах хорт хий цэгэн эх үүсвэртэй агаарын бохирдол үүснэ. Мөн автомашины хөдөлгөөн, газар шорооны ажлын үед машин тоног, төхөөрөмжийн дуу чимээ, чичиргээ бага зэрэг үүснэ. Энэхүү нөлөөлөл нь хүн, амьтанд ихээр нөлөөлөхгүй ба нөлөөллийн үргэлжлэх хугацаа нь харьцангуй бага байна.
4	Хөрсөн бүрхэвч	Мах ангилан ялгах, боловсруулах үйлдвэрийн талбайн 90%-д үйлдвэрийн барилга, хатуу хучилттай зам талбай байгуулсан, 10% нь зүлэг, ногоон байгууламжтай. Үйлдвэрийн талбайд хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, уулын хар хүрэн хөрс тархсан. Лабораторийн задлан шинжилгээний дүнгээс үзэхэд уг хөрс нь сул шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ялзмагийн агууламжаар дунд зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар дунд зэрэг, хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дундаж.
5	Ургамал	Ургамал газарзүйн мужлалаар Улаанбаатар хот нь Евро- Азийн хээрийн муж, Дагуур Монголын хээрийн хошуу, Дундад Халхын хээрийн тойрог, Өнжүүлийн дүүрэгт хамаарч байна. Ургамалжлын зүйлийн хувьд 17 овгийн 30 төрлийн нийт 33 зүйл ургамал бүртгэгдсэн байдаг. Мах ангилан ялгах, боловсруулах үйлдвэрийн талбай нь Улаанбаатар хотын хүн амын суурьшлын бүсэд байрлаж байгаа тул ургамалжилтын үндсэн бүлгэмдэл үүсмэл, хоёрдогч бүлгэмдлээр солигдсон байна. Эдэлбэр газарт зогдор улалж оролцсон жижиг дэгнүүлт үетэн- алаг өвст бүлгэмдэл тархсан байна.

6	Гадаргын ус	<p>Улаанбаатар хот нь Туул голын сав газрын II дэд хэсэгт байрладаг. Туул гол нь Хан Хэнтийн нурууны салбар Бага Хэнтий уулын ар, өврөөс эх авах Номин, Нэргүй голын бэлчрээс Туул нэрийг авч Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт Орхон голд цутгадаг. Голын ус хурах талбай нь 49'774.4 км² , голын нийт урт 717 км. Үүнээс 152 км нь Улаанбаатар хотоос дээш, 93 км нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт, 472 км нь нийслэл хотоос доош хэсэгт хамаарна. Туул голын сав газарт Монгол Улсын нийт хүн амын 46.3% нь амьдарч, дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг үйлдвэрлэж байна.</p> <p>Мах ангилан ялгах, боловсруулах үйлдвэрийн талбайн ойр орчимд гадаргын ус байхгүй.</p>
7	Гүний ус	<p>“Хаанхүнс импекс” ХХК нь үйлдвэрийн ажилчдын унд, ахуй болон үйлдвэрлэлийн технологийн усыг Ус суваг удирдах газартай байгуулсан гэрээний дагуу хотын цэвэр усны төвийн нэгдсэн шугамаас хангадаг.</p> <p>Үйлдвэрийн хэрэгцээнд ашиглаж буй ус нь ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартын шаардлагыг хангасан байна.</p>
8	Амьтан	<p>Үйлдвэрийн талбай нь Улаанбаатар хотын хүн амын төвлөрөл, суурьшлын бүсэд байрлаж байгаа тул амьтны зүйл хомс болсон байна.</p>

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалын дагуу хийж гүйцэтгэв. Мөн нөлөөллийн оноот үнэлгээний аргыг ашиглан нөлөөллийн үр дагавар, түүнд өртөх нутаг дэвсгэр болон байгаль орчны чадамжид оноо өгч дүгнэлт гаргав.

3.1 Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ

Төслөөс агаар орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь хүнсний хаягдлыг тодорхой зохицуулалтгүй ил задгай хаях, эсвэл ахуйн хатуу хаягдалтай нийлүүлж хаясан тохиолдолд агаар орчинд үнэрийн бохирдол үүсгэж болзошгүй байна.

Нөлөөллийн хэлбэр		Нөлөөллийн оноо								Нөлөөллийн түвшин
		H	A ₁	A ₂	A ₃	B ₁	B ₂	C ₁	Σ	
Үнэр	Үйлдвэрээс гарч буй технологийн хаягдал ус цуглуулах цооногоос дулааны улиралд орчны үнэрийн бохирдол үүсэж болзошгүй	-1	1	2	2	1	2	1	-10	Дунд
	Үйлдвэрээс гарч буй хаягдал түүхий эд, яс, дайвар бүтээгдэхүүнээс ажлын байрны дотор агаарт үнэрийн бохирдол үүсэх	-1	1	2	2	1	2	1	-10	Дунд
Хлорт фторт нүүрстөрөгч	Үйлдвэрийн агуулахын хөргөлтөд ашиглагдаж буй фреон-404 ашиглагддаг.	-1	1	1	2	1	1	1	-8	Бага
Эдгээр нөлөөллүүдийн 66.7% нь орчны агаарт үзүүлэх нөлөөлөл “дунд”, 33.7% нь бага байна.										

3.2 Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдлын үнэлгээ

“Мах ангилан ялгах, боловсруулах” төсөл нь нийт 6377 м² талбайд хэрэгжиж байгаа бөгөөд одоогоор төслийн нийт талбайн шимт хөрсний үе хөрс хуулалтад өртөж, хатуу хучилттай зам талбай байгуулсан байна.

3.3 Ургамал нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ

Үйлдвэрийн талбайн байршил (хотын хүн амын суурьшлын бүс) болон 6377 м² талбайг хатуу хучилттай зам талбай, үйлдвэрийн барилга барьж байгуулсан байгаа тул энэ хэмжээний талбайд тархсан ургамал нөмрөг түрэгдсэн байна.

3.4 Амьтны аймагт нөлөөлөх байдлын үнэлгээ

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх шууд нөлөөлөл байхгүй байна.

3.5 Усны нөөц, чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ

Үйлдвэр нь хотын ус хангамжийн төвийн шугамд холбогдсон бөгөөд үйлдвэрийн нийт ус хэрэглээ нь:

- Унд, ахуйд 140 хүн х 200 л/хон = 28.0 м³/хон, 10,220.0 м³/жил ус,
- Хиаман бүтээгдэхүүн: 10.0 тн/хон х 16.3 м³ /тн = 163.0 м³ /хон, 40,570.0 м³ /жил ус,
- Хагас боловсруулсан бүтээгдэхүүн: 1.0 тн/хон х 16.2 м³ /тн = 16.2 м³ /хон, 4,050.0 м³ /жил ус,
- Нийт 207.2 м³ /хон, 54,840.0 м³ /жил усыг ашигладаг байна.

3.6 Төслөөс нийгэм, эдийн засагт нөлөөлөх байдал, үнэлгээ

Мах ангилан ялгах, боловсруулах үйлдвэр нь нийт 140 хүнийг тогтвортой ажлын байраар ханган ажиллаж байна.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Мах ангилан ялгах, боловсруулах үйлдвэр” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан журмын баримтлан боловсрууллаа.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө, осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2025 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт **988,500.0 төгрөг** зарцуулахаар төсөвлөв.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, ₮	Давтамж	Нийт зардал, ₮	Хэрэгжих хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8
1. АГААРЫН ЧАНАР							
Үйлдвэрийн орчны тоосжилт нь агаар дахь тоосжилтын хэмжээг нэмэгдүүлэх боломжтой	Үйлдвэрийн гадна болон дотоор агаарт тогтмол чанарын шинжилгээ хийлгэх	Үйлдвэрийн дотор болон гадна агаар	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу			2025 онд	MNS 4585:2016 MNS 5885:2008
2. ХӨРСӨН БҮРХЭВЧ							
Ахуйн хатуу хог хаягдлыг тодорхой зохицуулалтгүй хаях нь хөрсний бохирдлын гол эх үүсвэр болох	Ахуйн хатуу хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах хогийн байршуулах, хог хаягдал цуглуулах байгууламжтай болох	Төслийн талбай	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу			2025 онд	Хог хаягдлын тухай хууль
3. УРГАМЛАН НӨМРӨГ							
Ногоон байгууламжийн арчилгаа	Усалгаа	Үйлдвэрийн талбайд байгаа зүлэг, модны суулгац	Дотоод төлөвлөлтөөр				-
	Тордолт						

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ногоон байгууламжийн арчилгаа	Усалгаа	Төслийн талбайд байгаа зүлэг, модны суулгац					2025 онд	
	Тордолт							
2025 ОНЫ НИЙТ ЗАРДАЛ						-		

ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай. Тус төслийн талбай орчимд түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палентологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Галын аюул үүсэх	Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах	Төслийн талбай	140 хүн	500,000.0₮	500,000.0₮	2025 он	-
Ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх	Ажилчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Ажилчид	140 хүн	Дотоод төлөвлөлтөөр		2025 он	-
	Ажилчдыг ажилд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	Ажилчид	140 хүн	Дотоод төлөвлөлтөөр		2025 он	-
	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар ХАБ-ын сургалт зохион байгуулах						-
2025 ОНЫ НИЙТ ЗАРДАЛ		500,000.0₮					

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн хатуу хаягдал	Үүссэн хог хаягдлыг Сонгинохайрхан дүүргийн ТҮК-тэй байгуулсан гэрээний дагуу өдөрт нэг удаа ачуулах	Төслийн талбай	тн	Гэрээний дагуу	-	-	-	Хог хаягдлын тухай хууль
2025 ОНЫ НИЙТ ЗАРДАЛ						-			

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
1	Хөрсний эрүүл ахуй	Төслийн талбайгаас	V/15	25,000.0₮	25,000.0₮	“Green lab” ХХК-ийн НӨАТ орсон үнийн дүнгээр тооцлоо.	MNS 5850:2019
2	Хөрсний хими, шинж физик чанар			20,000.0₮	20,000.0₮	Газарзүй - Геоэкологийн хүрээлэнгийн НӨАТ орсон үнийн дүнгээр	
3	Хөрсний хүнд металл			25,000.0₮	25,000.0₮	“Green lab” ХХК-ийн НӨАТ орсон үнийн дүнгээр тооцлоо.	
4	Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Ажилчдын ундны уснаас	V/15	50,000.0₮	50,000.0₮	“Монгол-Ус” ТӨХК-ийн үнийн дүнгээр тооцлоо.	MNS 4943:2015
5	Ундны усны бүрэн шинжилгээ			43,000.0₮	43,000.0₮		

6	Ундны усан дахь хүнд металлын агууламж			78,000.0₮	78,000.0₮		
7	Үйлдвэрийн хаягдал бохир усны шинжилгээ	Бохир ус цуглуулах цооног дахь уснаас	Улиралд 1 удаа	70,000.0₮	210,000.0₮	Газарзүй-геоэкологийн хүрээлэнгийн үнийн дүнгээр тооцлоо.	MNS 6561:2015
8	Орчны агаарын чанарын шинжилгээ	Үйлдвэрийн гадна, доторагаар	V/15	37,500.0₮	37,500.0₮	Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн дүнгээр тооцов.	MNS 4585:2016
9	Нийт зардал				488,500.0₮		

**АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээрүүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Дотоод төлөвлөлтөөр	2025 онд	“Хаанхүнс импекс” ХХК	-
Мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар ХАБ-ын сургалт зохион байгуулах	Осол, эрсдэлийн МТ-нд тусгагдсан			
Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Дотоод төлөвлөлтөөр			
Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулах	Осол, эрсдэлийн МТ-нд тусгагдсан			
2025 ОНЫ НИЙТ ЗАРДАЛ		-		

**АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГНӨЛӨӨЛЛИЙН
БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	БОМТ, БОМТ-ийн хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	Нийслэлийн байгаль орчны газар, Хаанхүнс импекс ХХК	Тайлан	Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний биелэлт тайлан	11-р сарын 01-ний дотор	-	Компанийн удирдлага, мэргэжилтнүүд	Улаанбаатар хот
2	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газар	Тайлан	Тухайн жилийн БОМТ	12-р сарын 1-ний дотор	-	“Хаанхүнс импекс” ХХК-ийн мэргэжилтнүүд БОМТ-г боловсруулах	Улаанбаатар хот
	2025 оны нийт зардал				-		

Хүснэгт №2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Үйл ажиллагааны төлөвлөгөө	Зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	-
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	500,000.0₮
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	-
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	488,500.0₮
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
Нийт дүн		988,500.0₮